

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



**Чингэлтэй дүүргийн “Гэмт хэрэг,  
аюулгүй байдал”-ын судалгаа 2015**

**Улаанбаатар хот  
2016 он**



## АГУУЛГА

- Гэмт хэргийн тухай ойлголт
- Нийслэлийн дүнд Чингэлтэй дүүргийн эзлэх хувь
- Чингэлтэй дүүргийн бүртгэгдсэн гэмт хэрэг



### Гэмт хэргийн тухай ойлголт


Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг **гэмт хэрэг** гэнэ. Гэмт хэрэг нь хүний идэвхтэй (үйлдэл) буюу идэвхгүй (эс үйлдэл) зан үйлээр дамжин илэрдэг. Үйлдэл хийх гэдэг нь хүний идэвхитэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ. Эс үйлдэл нь тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгоно. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж нь хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө, төр, нийгмийн эрх ашигт хор аюул учруулж буйгаар илэрхийлэгдэнэ. Гэм буруутай байх нь гэмт хэргийн үндсэн шинжийн нэг юм. Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцдоггүй. Монгол Улсын Үндсэн хуульд "...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд халдаан хэрэглэхийг хориглоно" хэмээн заасан байдаг. Гэм буруу нь санаатай болон болгоомжгүй гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Гэмт хэрэг үйлдэж байгаа хүн өөрийн үйлдэл, эс үйлдлийн улмаас бусдад учирч болох хор аюулыг урьдчилан мэдсэн боловч:

- уг хор аюулыг учруулахыг хүсч гэмт хэрэг үйлдсэн бол шууд санаатай үйлдсэн
- уг хор аюулыг хүсээгүй боловч түүнд зориуд хүргэсэн бол шууд бус санаатай үйлдсэн гэж тус тус үзнэ.

### Гэмт хэргийн ангилал

**Хөнгөн гэмт хэрэг:** Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсвэл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ. Хөнгөн гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүй.

Зураг 1. Чингэлтэй дүүргийн хэмжээнд гарсан Хөнгөн гэмт хэрэг, оны эцэс



Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2015 онд 1050 хөнгөн гэмт хэрэг бүртгэгдсэн ба 2013 оны мөн үеэс 3.1 хувиар, 2012 оны мөн үеэс 31.6 хувиар тус тус өссөн боловч мөнх оны мөн үеэс 10.1 хувиар буурсан байна.



**Хүндэвтэр гэмт хэрэг:** Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 251-500 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, 3-аас дээш 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсвэл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэнэ.

Зураг 2. Чингэлтэй дүүргийн хэмжээнд гарсан Хүндэвтэр гэмт хэрэг, оны эцэс



**Хүнд гэмт хэрэг:** Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 251-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 5 жилээс дээш 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

Зураг 3. Чингэлтэй дүүргийн хэмжээнд гарсан Хүнд гэмт хэрэг, оны эцэс




2015 оны байдлаар дүүргийн хэмжээнд хүнд хэрэг 142 хэрэг бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар буюу 30 хэргээр буурсан байна. 2012 оны мөн үеэс 30.4 хувиар,



2013 оны мөн үеэс 19,8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь нийгэмд ард түмэн амар тайван амьдрахад эерэгээр нөлөө үзүүлнэ.


**Онц хүнд гэмт хэрэг:** Эрүүгийн хуулийн тусгай ангид 10 жилээс дээш 15 жил хүртэл хугацаагаар хорих, онцгой тохиолдолд 25 жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэнэ.

Зураг 4. Чингэлтэй дүүргийн хэмжээнд гарсан онц хүнд гэмт хэрэг, оны эцэс



Онц хүнд гэмт хэрэг дүүргийн хэмжээнд 51 бүртгэгджээ. 2012 оны мөн үеэс 2 хувиар өссөн ч, өмнөх оны мөн үеэс мөн 2 хувиар буурсан нь сайн үзүүлэлттэй байна.

Зураг 5. Бүртгэгдсэн гэмт хэрэг 2015 он, /хороодоор/





## НИЙСЛЭЛ ХОТЫН ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

Хүснэгт 1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр жил бүрийн оны эцэст дүүргээр

	Гэмт хэрэг төрлөөр									
	Хүн амь	Учрал	Залилан	Хүчин	Танхай	Булаалт	Хулгай	ӨМӨНӨИ	Дээрэм	Бусад
2009 он	15	45	140	19	101	12	428	495	64	179
2010 он	17	79	113	14	115	13	286	494	29	108
2011 он	12	61	110	18	205	18	291	446	43	265
2012 он	19	32	159	20	240	22	446	488	59	198
2013 он	16	35	191	25	201	25	571	614	72	365
2014 он	16	18	288	18	161	18	722	809	66	306
2015 он	13	10	291	13	146	14	722	524	41	480

Нийслэлийн Цагдаагийн газрын мэдээгээр нийслэл Улаанбаатар хотод 2015 оны жилийн эцсийн байдлаар 17.9 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.3 хувь буюу 0.7 мянган хэргээр өсчээ. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээсхамгийн бага хэрэг бүртгэгдсэн ньХан-Уул дүүрэг 1.4 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн ба 7.7 хувьтай байна. Баянзүрх дүүрэгт 4.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийслэл хотын нийт гэмт хэргийн хамгийн өндөр буюу 23.8 хувийг эзэлж байна. Чингэлтэй дүүрэгт 2.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь Улаанбаатар хотын нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 12.5 хувийг буюу төвийн 6 дүүргээс 5-д жагссан байна.

Хүснэгт 2. Бүртгэгдсэн гэмт хэрэг, дүүргүүдээр 2009-2015 оны эцэс

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	251	218	278	278	236	311
Багахангай	14	11	20	31	23	21
Баянгол	1938	2009	2372	2521	2775	2951
Баянзүрх	2188	2137	2739	3742	4263	4272
Сүхбаатар	1639	1643	2102	2416	2593	3085
Сонгинохайрхан	2081	1923	2127	2778	3039	3232
Налайх	302	242	290	302	339	423
Хан-Уул	1090	1121	1175	1236	1484	1390
Чингэлтэй	1360	1469	1807	2115	2392	2254
Нийслэлийн дүн	10863	10773	12910	15419	17144	17939



Зураг 6. Бүртгэгдсэн гэмт хэрэг, дүүргээр 2015 он



Хүснэгт 3. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, нийслэлээр


	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	59.4	61.8	67.2	63.6	71.4	71.7
Багахангай	100.0	100.0	0.0	100	71.4	100.0
Баянгол	58.0	61.8	64.7	62.5	63.8	67.1
Баянзүрх	53.7	57.1	39.6	51.8	48.2	53.8
Сүхбаатар	61.2	58.3	46.0	53.6	55.2	57.0
Сонгинохайрхан	41.1	57.9	58.9	60.3	58.5	59.9
Налайх	68.0	64.7	65.8	60.5	76.4	73.5
Хан-Уул	54.8	58.7	58.4	56.0	59.5	63
Чингэлтэй	59.8	60.0	55.1	57.8	54.8	58.6
Нийслэлийн дүн	53.5	58.8	51.7	56.5	55.4	58.9

Зураг 7. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, илрээгүй гэмт хэргийн тоо






Зураг 8. Гэмт хэрэг үйлдэгсэд, дүүргээр 2015 он



Нийслэлийн Цагдаагийн газрын мэдээгээр гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2015 оны байдлаар 14511 байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буюу 1133 хүнээр өссөн байна. Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэгт холбогдсон нийт иргэдийн 53.0 хувь буюу 6711 нь ажилгүй иргэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 14.6 хувь буюу 982 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэрэгт холбогдсон нийт иргэдийн 11.7 хувь нь Чингэлтэй дүүрэгт байна.

Зураг 9. Чингэлтэй дүүргийн нийт гэмт хэрэгт холбогдсон, нийгмийн байдлаар 2015








Хулгайн гэмт хэргийг Эрүүгийн тухай хуулинд “Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэдэг” гэж заасан байдаг. 2015 оны байдлаар дүүргийн хэмжээнд нийт 721 хулгайн гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувь буюу 1 хэргээр, 2013 оны мөн үеэс 27.4 хувиар буюу 155 хэргээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 10. Хулгайн гэмт хэрэг, 2015 он /дүүргээр/



Үүнээс мал хулгайлах 1 хэрэг бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 88.9 хувь буюу 8 хэргээр, 2013 оны мөн үетэй харьцуулахад 75 хувь буюу 3 хэргээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин авто тээврийн хэрэгсэл хулгайлах 7 хэрэг бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.7 хувь буюу 5 хэргээр буурсан, 2013 оны мөн үетэй харьцуулахад 40 хувь буюу 2 хэргээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Танилцуулга бэлтгэсэн:  
мэргэжилтэн Д.Ганзул



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

[www.1212.mn](http://www.1212.mn)

[www.UBSTAT.mn](http://www.UBSTAT.mn)

[WWW.CHINGELTEI.GOV.MN](http://WWW.CHINGELTEI.GOV.MN)

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС  
Утас: 11-310767